

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жинст сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/136/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2024.02.23</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Ахлах аудитор М.Алтантуяа Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	3
Аудитын гол асуудал.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.1 Төлбөрийн акт.....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2024.02.23 № 2/53

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жинст сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жинст сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагын газар эзэмшихтэй холбоотой нь зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлаас хэтрээгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын хүрээнд 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

5020208

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

A large, stylized handwritten signature in black ink, written over a red rectangular stamp. The signature is fluid and cursive, starting with a large loop and ending with a long horizontal stroke that extends to the right.

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	17,014,300.00	42,484,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	17,014,300.00	42,484,500.00
35100	Түүхий эд материал	410,000.00	410,000.00
35110	Тусгай зориулалттай материал	340,000.00	340,000.00
35130	Эм боох материал	70,000.00	70,000.00
35400	Хангамжийн материал	16,604,300.00	21,864,800.00
35410	Бичиг хэргийн материал	177,500.00	132,000.00
35420	Аж ахуйн материал	1,089,000.00	1,189,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	700,000.00	700,000.00
35450	Барилгын засварын материал	618,000.00	618,000.00
35470	Бусад хангамжийн материал	14,019,800.00	19,225,800.00
35600	Мал амьтад	0	20,209,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	971,222,164.81	1,664,211,390.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	971,222,164.81	1,664,211,390.80
39200	Биет хөрөнгө	959,766,206.65	1,653,342,932.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	757,174,372.50	1,225,103,624.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	-134,378,837.96	-145,233,169.42
39203	Авто-тээврийн хэрэгсэл	111,544,800.00	196,658,855.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-72,351,644.83	-29,402,818.59
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	233,268,660.10	254,771,660.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	-149,690,165.01	-191,590,759.97
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,716,455.91	51,516,455.91
39208	Хуримтлагдсан элэгдэл	-39,003,368.75	-42,378,272.69
39214	Бусад үндсэн хөрөнгө	392,224,192.90	551,774,192.90
39215	Хуримтлагдсан элэгдэл	-190,258,258.21	-218,396,835.20
39217	Ном	520,000.00	520,000.00
39300	Биет бус хөрөнгө	11,455,958.16	10,868,458.00
39301	Програм хангамж	3,700,000.00	3,700,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,112,499.84	-3,700,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,868,458.00	10,868,458.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	988,236,464.81	1,706,695,890.80
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	988,236,464.81	1,706,695,890.80
51	Засгийн газрын хувь оролцоо	988,236,464.81	1,706,695,890.80
51100	Засгийн газрын оруулсан капитал	382,993,124.00	382,993,124.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	382,993,124.00	382,993,124.00
51200	Хуримтлагдсан үр дүн	301,358,317.93	1,021,305,053.46
51210	Өмнөх үеийн үр дүн	332,577,143.11	302,845,627.47
51220	Тайлант үеийн үр дүн	-31,218,825.18	718,459,425.99
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	303,885,022.88	302,397,713.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	988,236,464.81	1,706,695,890.80

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	496,584,505.90	1,431,276,503.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	72,985,473.90	833,560,654.00
120	Нийтлэг татварын бус орлого	72,985,473.90	833,560,654.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	700,000.00	900,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	700,000.00	900,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	72,285,473.90	812,450,954.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	20,209,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	423,599,032.00	597,715,849.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,861,832.00	9,029,549.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,861,832.00	9,029,549.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	412,737,200.00	588,686,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	412,737,200.00	588,686,300.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	514,193,128.73	704,258,921.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	514,193,128.73	704,258,921.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	484,898,771.99	683,541,774.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,571,813.84	372,368,946.14
210101	Үндсэн цалин	191,420,081.34	253,785,724.28
210102	Нэмэгдэл	43,992,033.50	98,194,089.96
210104	Урамшуулал	5,159,699.00	20,389,131.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,747,031.25	45,314,075.09
210201	Тэтгэврийн даатгал	20,340,699.76	31,637,809.14
210202	Тэтгэмжийн даатгал	2,335,194.78	3,722,095.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,944,230.57	2,977,676.32
210204	Ажилгүйдлийн даатгал	339,529.76	632,275.83
210205	Эрүүл мэндийн даатгал	3,787,376.38	6,344,218.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,418,282.00	23,313,824.00
210301	Гэрэл, цахилгаан	2,841,944.00	5,611,024.00
210302	Түлш, халаалт	14,576,338.00	17,502,800.00
210303	Цэвэр, бохир ус	0	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,184,450.00	26,292,775.00
210401	Бичиг хэрэг	3,418,050.00	3,863,225.00
210402	Тээвэр, шатахуун	22,945,300.00	21,073,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,096,100.00	453,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	445,000.00	902,500.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	280,000.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,326,000.00	4,864,000.00
210604	Урсгал засвар	3,326,000.00	4,864,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,729,000.00	7,757,500.00
210702	Дотоод албан томилолт	3,729,000.00	7,757,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,925,941.00	29,744,231.00

Жинст сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,806,941.00	25,367,731.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	5,000.00	22,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогчоо	50,000.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	136,996,253.90	173,886,422.94
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,821,400.00	56,732,950.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	102,174,853.90	117,153,472.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,294,356.74	20,717,147.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,857,082.00	15,987,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,357,082.00	0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	14,587,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,437,274.74	4,729,847.77
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,437,274.74	4,729,847.77
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-17,608,622.83	727,017,581.06
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	13,610,202.35	8,558,155.07
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	13,180,202.35	8,558,155.07
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	430,000.00	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-31,218,825.18	718,459,425.99

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	424,299,032.00	598,615,849.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	700,000.00	900,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	700,000.00	900,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	700,000.00	900,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	700,000.00	900,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	423,599,032.00	597,715,849.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,861,832.00	9,029,549.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,861,832.00	9,029,549.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	412,737,200.00	588,686,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	412,737,200.00	588,686,300.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	411,958,032.00	592,365,949.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	411,958,032.00	592,365,949.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	382,663,675.26	571,648,801.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,410,571.01	372,368,946.24
210101	Үндсэн цалин	199,061,090.00	257,924,442.46
210102	Нэмэгдэл	41,349,481.01	112,965,853.78
210104	Урамшуулал	0	1,478,650.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,747,031.25	45,314,074.99
210201	Тэтгэврийн даатгал	20,340,699.76	31,637,809.14
210202	Тэтгэмжийн даатгал	2,335,194.78	3,722,095.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,944,230.57	2,977,676.32

Жинст сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210204	Ажилгүйдлийн даатгал	339,529.76	632,275.73
210205	Эрүүл мэндийн даатгал	3,787,376.38	6,344,218.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,593,482.00	23,313,824.00
210301	Гэрэл, цахилгаан	3,017,144.00	5,611,024.00
210302	Түлш, халаалт	14,576,338.00	17,502,800.00
210303	Цэвэр, бохир ус	0	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,987,270.00	25,592,275.00
210401	Бичиг хэрэг	3,357,050.00	3,685,725.00
210402	Тээвэр, шатахуун	21,096,120.00	20,630,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	935,100.00	675,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	599,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,944,000.00	4,864,000.00
210604	Урсгал засвар	3,944,000.00	4,864,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,729,000.00	7,757,500.00
210702	Дотоод албан томилолт	3,729,000.00	7,757,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,224,921.00	29,744,231.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,105,921.00	25,367,731.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	5,000.00	22,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	50,000.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,027,400.00	62,693,950.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,027,400.00	62,693,950.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	29,294,356.74	20,717,147.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,857,082.00	15,987,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	23,357,082.00	0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	14,587,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,437,274.74	4,729,847.77
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,437,274.74	4,729,847.77
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	12,341,000.00	6,249,900.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	12,341,000.00	6,249,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,341,000.00	6,249,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	12,341,000.00	6,249,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,341,000.00	6,249,900.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-12,341,000.00	-6,249,900.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	382,993,124.00	328,183,918.35	308,278,247.64	1,019,455,289.99
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	24,298,895.47	24,298,895.47
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	382,993,124.00	328,183,918.35	332,577,143.11	1,043,754,185.46
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-24,298,895.47	0	-24,298,895.47

Жинст сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

9	Тайлант үеийн үр дүн	0	0	-31,218,825.18	-31,218,825.18
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	382,993,124.00	303,885,022.88	301,358,317.93	988,236,464.81
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	382,993,124.00	303,885,022.88	301,358,317.93	988,236,464.81
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	1,487,309.54	1,487,309.54
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	382,993,124.00	303,885,022.88	302,845,627.47	989,723,774.35
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-1,487,309.54	0	-1,487,309.54
19	Тайлант үеийн үр дүн	0	0	718,459,425.99	718,459,425.99
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	382,993,124.00	302,397,713.34	1,021,305,053.46	1,706,695,890.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	589,686,300.00	584,856,452.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	589,686,300.00	584,856,452.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	573,599,000.00	568,869,152.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	373,527,300.00	372,368,946.24
210101	Үндсэн цалин	257,995,800.00	257,924,442.46
210102	Нэмэгдэл	114,031,500.00	112,965,853.78
210104	Урамшуулал	1,500,000.00	1,478,650.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,678,600.00	45,314,074.99
210201	Тэтгэврийн даатгал	31,761,400.00	31,637,809.14
210202	Тэтгэмжийн даатгал	3,854,300.00	3,722,095.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,083,400.00	2,977,676.32
210204	Ажилгүйдлийн даатгал	770,900.00	632,275.73
210205	Эрүүл мэндийн даатгал	7,208,600.00	6,344,218.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,655,500.00	23,313,824.00
210301	Гэрэл, цахилгаан	5,950,000.00	5,611,024.00
210302	Түлш, халаалт	17,505,500.00	17,502,800.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,834,100.00	25,592,275.00
210401	Бичиг хэрэг	3,733,000.00	3,685,725.00
210402	Тээвэр, шатахуун	20,692,200.00	20,630,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	808,900.00	675,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600,000.00	600,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,900,000.00	4,864,000.00
210604	Урсгал засвар	4,900,000.00	4,864,000.00
2107	Томиллолт, зочны зардал	7,871,000.00	7,757,500.00
210702	Дотоод албан томиллолт	7,871,000.00	7,757,500.00



Жинст сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,776,500.00	20,714,682.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,340,000.00	16,338,182.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	22,500.00	22,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	50,000.00	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564,000.00	3,564,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	300,000.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70356000.00	68943850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	70,356,000.00	68,943,850.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16087300.00	15987300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,087,300.00	15,987,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,587,300.00	14,587,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,400,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	589,686,300.00	589,586,300.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	588,686,300.00	588,686,300.00
132001	Орон нутгийн төсвөөс	588,686,300.00	588,686,300.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	900,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	900,000.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	22	22
620001	Удирдах ажилтан	03	03
620002	Гүйцэтгэх ажилтан	19	19
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	22	22
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	09	09
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	06	06
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	07	07

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,029,549.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,029,549.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,029,549.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,029,549.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,029,549.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9029549.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,029,549.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,029,549.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Жинст сумын ЗДТГ нь "Монгол Улсын Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сумын орон нутгийн нийгэм эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсыг чандлан сахиулах, төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэхэд оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албан хэрэгжүүлдэг бөгөөд 2021-2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, зөвлөн туслах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.

Түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жинст сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь аймгийн ЗДТГ-ын СТСХ-ээс 2022 онд хэвлүүлсэн "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жинст сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 718,459.4 мянган төгрөг буюу 73 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
БАРАА МАТЕРИАЛ	17,014.3	42,484.5	25,470.2
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,560,016.9	2,294,913.2	734,896.3
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	(588,794.8)	(630,701.9)	(-41,907.1)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	988,236.5	1,706,695.9	718,459.4
Засгийн газрын хувь оролцоо	988,236.5	1,706,695.9	718,459.4
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	988,236.5	1,706,695.9	718,459.4

Бараа материалын дансны үлдэгдэл 42,484.5 мянган төгрөг болж 25,470.2 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 107 дугаар / захирамжаар 20,209.7 мянган төгрөгийн малыг хүлээн авч үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн, бусад хангамжийн материал данс 5,206.0 мянган төгрөгөөс өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,294,913.2 мянган төгрөг болж оны эхний үлдэгдэл 734,896.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,706,695.9 мянган төгрөг болж 718,459.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 628,137.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 628,137.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 38,451.2 мянган төгрөгөөр бууруулж 589,686.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 588,686.3 мянган төгрөгийн эх үүсвэрийг, туслах үйл ажиллагааны орлогоос 900.0 мянган төгрөгийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 584,856.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 584,856.4 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэлтэй холбоотой зардал 372,368.9 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд 45,314.1 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 23,313.8 мянга, Засаг даргын нөөц хөрөнгө 68,943.8 мянган төгрөг зарцуулсан нь голлох нөлөө үзүүлж байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 9029.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 9029.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жинст сумын ЗДТГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, чанарын хяналтыг газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хэрэгжүүлсэн.

Жинст сумын ЗДТГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 1а/131 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсөв 589,686.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,845.3 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,633.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт



Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2023 оны гэрэл цахилгааны зардлыг 341.7 мянга, шуудан холбооны зардлыг 133.3 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 1,412.1 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 316,684.9 мянган төгрөгийн 24 мэдээлэл, 6.4.8 “Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл” -д заасан 38.225.9 мянган төгрөгийн 24 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 6.4.5 “Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын мөнгөн гүйлгээ”-д заасан 5,000.0 мянган төгрөгийн орлогын 1 гүйлгээг мэдээлж Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар Сумын Засаг даргын 2023.07.20-ны өдрийн “100 жилийн ойн баярыг угтан бэлтгэл хангуулах тухай” А/101 дугаар захирамжаар 2,500.0 мянган төгрөгөөр цагаан идээ бэлтгэсэн зөрчилд төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулж ажилласан.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж аудитаар алдаа зөрчил гараагүй болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар анхаарал татсан асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

1. Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй болно.

Аудитаар нийт 2500.0 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрснээс 2500.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчил арилгах албан шаардлага 1 хүргүүлэв. өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2500.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 6,633.9 мянган төгрөгөөс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Сумын Засаг даргын 2023.07.20-ны өдрийн “100 жилийн ойн баярыг угтан бэлтгэл хангуулах тухай” А/101 дугаар захирамжаар 2,500.0 мянган төгрөгөөр цагаан идээ бэлтгэсэн.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 т “хуулиар зөвшөөрөөгүй бусад” төлбөрийн санхүүжүүлэхгүй болно гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох буруутай албан тушаалтнаар 2,500.0 мянган төгрөгийг буцаан төлүүлэхээр төлбөрийн актыг тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1 Жинст сумын ЗДТГ-ын газар эзэмших гэрчилгээг нягтлан бодох бүртгэл, аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн судалгаатай тулган шалгахад 241093 мкв талбай бүхий 12 газар байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлгүй, үүнээс тэжээлийн ургамлын талбай, бэлчээр дэх уст цэг, мал эмнэлгийн үйлчилгээний зориулалттай 7 газар нь газрын гэрчилгээ, газар эзэмшүүлэх гэрээ байгуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын газар эзэмших гэрчилгээний баримт бичгийн зөрчлийг арилгаж газрыг дахин үнэлж нягтлан бодох бүртгэлд бүртгэх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Үүнээс Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын Засаг даргын 2023.07.20-ны өдрийн “100 жилийн ойн баярыг угтан бэлтгэл хангуулах тухай” А/101 дугаар захирамжаар 2,500.0 мянган төгрөгөөр цагаан идээ бэлтгэсэн	1	2500.0	1	2500.0				
Жинст сумын ЗДТГ-ын газар эзэмших гэрчилгээг нягтлан бодох бүртгэл, аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн судалгаатай тулган шалгахад 241093 мкв талбай бүхий 12 газар байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлгүй, үүнээс тэжээлийн ургамлын талбай, бэлчээр дэх уст цэг, мал эмнэлгийн үйлчилгээний зориулалттай 7 газар нь газрын гэрчилгээ, газар эзэмшүүлэх гэрээ байгуулаагүй байна.	1	0			1	0		
Нийт дүн	2	2500.0	1	2500.0	1	0		

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 38/АО580/237
БКА-2024/136/НА-ОТА-ТЦ8
Зөрчил арилгуулах тухай

Номгон

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Жинст сумын ЗДТГ-ын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жинст сумын ЗДТГ-ын газар эзэмших гэрчилгээг нягтлан бодох бүртгэл, аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн судалгаатай тулган шалгахад 241093 мкв талбай бүхий 12 газар байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлгүй, үүнээс тэжээлийн ургамлын талбай, бэлчээр дэх уст цэг, мал эмнэлгийн үйлчилгээний зориулалттай 7 газар нь газрын гэрчилгээ, газар эзэмшүүлэх гэрээ байгуулаагүй байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 “ бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” заавал бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагын газар эзэмших гэрчилгээний баримт бичгийн зөрчлийг арилгаж, эрх бүхий байгууллагаар газрын үнэлгээг хийлгэж нягтлан бодох бүртгэлд бүртгэж зөрчлийг арилган, хэрэгжилтийг нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 05 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹

5040116

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жинст сумын ЗДТГ-ын дарга З.Цэрэндорж, нягтлан бодогч Б.Батбаяр нарт хариуцуулав²³.


АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР :

АХЛАХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

М.АЛТАНТУЯА



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно


**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 27 АОСБ0237
БНА-2024/136/НА-СН-ТЦЗ

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Жинст сумын ЗДТГ-ын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын Засаг даргын 2023.07.20-ны өдрийн “100 жилийн ойн баярыг угтан бэлтгэл хангуулах тухай” А/101 дугаар захирамжаар 2,500,000 төгрөгөөр цагаан идээ бэлтгэн төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 т “хуулиар зөвшөөрөөгүй бусад” төлбөрийн санхүүжүүлэхгүй болно гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийг 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Байгууллагын хөрөнгөөс зориулалт бусаар зарцуулсан 2,500,000.0 /Хоёр сая таван зуун мянган/ төгрөгийг ЗДТГ-ын дарга, нягтлан бодогчоор төлүүлж, төлбөрийг сумын ЗДТГ-ын 100030555001 тоот дансанд төвлөрүүлэх¹.
2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2024 оны 03

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

5050082

дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Жинст сумын ЗДТГ-ын дарга З.Цэрэндорж, нягтлан бодогч Б.Батбаяр нарт хариуцуулав²³.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР :

АХЛАХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

М.АЛТАНТУЯА



² Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно